

ОРОЛЦОГЧДОД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

**Нийгэмшүүлэх Циркийн Суурь Сургалт -
Хоёрдугаар хэсэг**

Энэхүү гайхалтай гарын авлагын эзний нэр бол:

Улаанбаатар, Монгол улс
2013 оны 3 дугаар сарын 25-29

Сургагч багш нар:
Изабелл Массе
Филип Соломон

CIRQUE DU SOLEIL™



ӨМНӨХ ҮГ

Cirque du Soleil буюу Нарны Цирк нь мөрөөдлөө дагах нөөц бололцоо байсан цагаас эхлэн, тус цирк нь нийгэмшүүлэх циркээр дамжуулан эрсдэлд буй залуу үеийнхэнтэй холбоотой байхыг сонгосон билээ. Энэхүү чин үнэнч зүтгэлийн ачаар 1995 онд *Cirque du Monde* буюу Дэлхийн Циркийн сүлжээг бий болсон бөгөөд үүнээс таван жилийн дараа Нийгэмшүүлэх циркийн сургагч багш нар бэлтгэгдэж, Нийгэм соёлын ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөр гарсан байна. Хамгийн сүүлд Нарны Цирк нь нийгэмшүүлэх циркэд зориулсан боловсролын цуврал арга хэрэгслийг хөгжүүлэх тал дээр хөрөнгө оруулалт хийсэн.

Оролцогчдод зориулсан гарын авлага нь энэхүү цувралын чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Нарны Циркийн мэргэжлийн ур чадвар болон 1995 оноос хойшхи тус циркийн олон хамтрагч нарын ур чадварт үндэслэж тус гарын авлагыг гаргаж байгаа юм. Дэлхийн олон оронд уулзаж танилцаж байсан зуун зуун сургагч багш нар, нийгэм соёлын ажилтнууд, зохицуулагчид болон судлаачдын үнэтэй хувь нэмэргүйгээр энэхүү ном гарах боломжгүй байсан байх.

Тэмдэглэлийн дэвтэр, лавлах хэрэгсэл болон Оролцогчдод зориулсан гарын авлагад нийгэмшүүлэх циркийн сургалтын үеэр яригдах бүх сэдэвчилсэн асуудлуудыг тусгасан байгаа. Сэдэв бүрт бид зорилтууд, ерөнхий ойлголт төсөөлөл болон холбогдох түлхүүр үгнүүдийг жагсаасан билээ. Хавсралтанд төрөл бүрийн баримт бичгийн цуглуулга болон нийгэмшүүлэх циркийн төслийн төлөвлөгөө болон хэрэгжүүлэх талаарх практикт хэрэглэж болохуйц сүлжээг оруулсан байгаа. Түүнчлэн, тэмдэглэлээ хийх хангалттай зай танд үлдээсэн бөгөөд сургалтаар сурч олж мэдсэн зүйлээ өөрийн үгээр буулган тэмдэглэх боломжтой болж байгаа юм.

Сургалтанд тань амжилт хүсье!

ТАЛАРХАЛ

Бүтээлийн зохицуулагч: Дэвид Симард

Туслах зохицуулагч: Клаудиа Мариса Рибейро

Агуулгыг баталсан: Эммануэл Бошу, Лино де Жиованни, Элен Бруне

Хамтран зүтгэгчид: Мишель Лафортун, Элиза Монтарули, Норманд Эбер, Лино де Жиованни, Стефан Батинь, Элен Бруне,

Анни Бүшар, Лорэнзо Занэтти, Дирс Морелли, Эммануэл Бошу, Дэвид Симард, Андреа Семиноро, Жан-Рок Ашаар, Даниел Туркотт,

Жоселин Линдсэй, Кристиан Баррет, Эдит Годе, Денис Лемэй, Ришард Прэжан

Англи хувилбарын хэлний зохицуулагч: Клаудиа Мариса Рибейро

Франц хэлнээс англи хэлрүү орчуулсан: Адриана Паланка

Хэл шинжлэлийн үүднээс засварлаж, англи хувилбарыг засварлан хянасан: Алексис Диамонд

Уран сайхны чиглэл өгсөн: Пиер Демарая

График дизайн: Мариа Мазелл

Хянан тохиолдуулсан: Доминик Пикар

Гэрэл зургийг: Габриел Бэнжамин Перэ Робл (“Табо” хочтой)

Зохиогчийн эрхийн зөвшөөрөлгүй аливаа хэлбэрээр өөрчлөн боловсруулахыг хатуу хориглоно.

Үүнийг зөрчсөн тохиолдолд иргэний болон эрүүгийн хэрэгт тооцно.

Зохиогчийн эрхийг баталгаажуулсан болно.

Канад улсад бүтээв.

CIRQUE DU SOLEIL



© 2012 Cirque du Soleil

cirquedusoleil.com

Нарны Цирк буюу Cirque du Soleil нь Нарны Циркийн эзэмших тэмдэг бөгөөд лицензтэй ашиглагддаг болно.

НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРКИЙН ҮНДСЭН СУРГАЛТ

Cirque du Soleil буюу Нарны Циркийн нийгэмшүүлэх циркийн үндсэн сургалтын хөтөлбөр нь эрсдэлд буй залууст зориулсан нийгэмшүүлэх циркийн сургалт явуулах циркийн сургагч багш нар болон нийгмийн ажилтнуудыг бэлтгэх зорилготой юм. Мөн энэхүү сургалт нь нийгэмшүүлэх циркийн оролцооны талаарх ерөнхий ойлголтыг дээрх хүмүүст ойлгуулахыг хичээх болно. Түүнчлэн энэхүү хөтөлбөр нь олон үндэстний янз бүрийн орчинд амьдарч буй хамтрагч нартайгаа зөв зохистой харилцахад шаардлагатай ур чадварыг хөгжүүлэхийг зорино.

СУРГАЛТЫН ЕРӨНХИЙ ЗОРИЛТУУД

- Хувийн болон мэргэжлийн маш сайн ёс зүйг хөгжүүлэх;
- Шинийг санаачилсан, оролцоонд тулгуурласан заах арга барилын үндэс суурийг танилцуулах;
- Олон нийтэд суурилсан сурах орчныг бий болгох;
- Урлагийг хувь хүн талаасаа хөгжүүлэх арга хэрэгсэл болгох.

ГАРЧИГ

ТУРШИЛТААР ТАНИН МЭДЭХЭД СУРАЛЦАХ ҮЕ ШАТ	4
НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК	5
ХАРИЛЦАА ХОЛБОО	9
ЗӨРЧЛИЙН МЕНЕЖМЕНТ	15
ХОСЛОН ЗААХ БА БҮЛГИЙН МЕНЕЖМЕНТ	21
СОЁЛ ХООРОНДЫН ХАРИЛЦАА	27
ТҮНШЛЭЛ	33
ХАВСРАЛТ	37



ТУРШИЛТААР ТАНИН МЭДЭХЭД СУРАЛЦАХ ҮЕ ШАТ

Энэхүү хэсэгт бид туршилтаар танин мэдэхэд суралцах үе шатын дөрвөн хэсэг болох туршлага, ажиглалт, нэгтгэх болон нэвтрүүлэх гэсэн хэсгүүдэд голлон анхаарна. Хэсэг бүр нь хувь хүний өөрийн суралцах янз бүрийн арга барилыг тусгасан байгаа. Тухайлбал, зарим хүмүүс юу сурч байгаагаа мэдрэх хэрэгтэй байдаг – сэтгэл хөдлөлөөр – зарим нь ажиглаж, тунгаан бодож, анализ хийж, аль эсвэл асуулт тавихыг илүүд үздэг бол харин бусад нь үйл хөдлөлөөр суралцдаг байна. Энэхүү загварын бүх дөрвөн хэсгийг туршиж, ашиглаж үзснээр янз бүрийн арга барилаар суралцдаг хүмүүс утга учрыг нь олох болно.

Энэхүү сургалтын үеэр санал болгох үйл ажиллагаанууд нь туршилтаар танин мэдэхэд суралцах үе шатын дөрвөн хэсгийн дагуу зохицуулагдсан.

СУРАЛЦАХ ҮЕ ШАТ

1. ТУРШЛАГА

Суралцагчидаас өмнөх туршлагаудаа эргэн санаж, суралцахад нь дөхөм, чиглэл болдог туршлагаасаа хуваалцахыг хүсэх.

Ямар нэгэн зүйл болж байна!



2. АЖИГЛАЛТ

Биеийн бус хэлийг ашиглах нь хувь хүний харилцаа, хөндлөнгөөс оролцох болон нөхцөл байдлыг суралцахад чухал чадвар болдог.

Юу болсон бэ?



3. НЭГТГЭХ

Туршлагаас гарсан шалтгаан болон үр дагаврыг тодорхойлж, ажиглалтыг харьцуулж, судалгааны дүгнэлтүүдээ нэгтгэх.



4. НЭВТРҮҮЛЭХ

Шинээр олж авсан мэдлэгээ нэвтрүүлэх аль эсвэл ирээдүйд хэрхэн нэвтрүүлж болох талаар ярилцах.

Миний дадалтай ямар холбоотой вэ?



НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК

ЗОРИЛТ

Энэхүү бүлгийн төгсгөлд сургагч багш болон нийгмийн ажилтан дараах ойлголттой болсон байна:

1. Нийгэмшүүлэх циркийн тухай зохих ойлголтын талаар
2. Нийгэмшүүлэх циркийг тодорхойлох зарчим, зорилтуудын талаар
3. Нийгэмшүүлэх цирк нь нэг төрлийн нийгмийн оролцоо болох талаар

Бид 2009 онд Бэи-Сайн-Поул-д болсон Дэлхийн Циркийн жил бүрийн чуулганд оролцож байлаа. Шөнийн нэг цагийн үед би оролцогч залуустай тэрхүү хамтдаа өнгөрөөсөн гайхалтай сайхан өдрийн тухай ярилцаж суутал тэдний нэг нь тэр өдөр бичсэн өөрийн шүлгийг уншихийг хүссэн юм.

Тэр шүлэгт: “Цирк надад хүчтэй нөлөөлж, амьдралыг минь өөрчиллөө. Цирк намайг шинэ арга барилд суралцахад тусалж, миний хүч чадал, нөөц чадамжийг нээж өглөө. Би бүх л амьдралынхаа туршид циркээр хичээллэж - циркээр амьсгалж, амьдармаар байна. Энэ бүхэн надад шинийг мөрөөдөх хүсэл эрмэлзэл төрүүлж байна.” гэсэн байв. Дэлхийн өөр олон орноор явж байхад үүнтэй төстэй сэтгэгдэл сонсож, залуу үеийнхнийг өөрсдийн хүч чадал, авьяас билгээ нээн илрүүлж, урам зоригоо олж байхыг харах надад хувь тохиол тохиолдож байсан. Би эдгээр сэтгэгдлийг сонсох бүрт, энэхүү туршилага нь хувь хүний болон нийгмийн өөрчлөлтөд хүчтэй хөшүүрэг хэрхэн болж чадахыг би илүү бүрэн дүүрэн ойлгох шиг болдог. Дэлхий даяар хүүхэд залуучууд тайзан дээр хөл тавьж ирээдүйгээ өөрсдөө бүтээх сонголт хийж байна. Тийм хүүхэд залуучуудын хувьд Нийгэмшүүлэх цирк нь агуу том гараа болж байна.

Лино Де Жиованни, Нийгэмшүүлэх циркийн сургалтын менежер
Cirque du Soleil буюу Нарны Цирк, Монтреал





НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Нийгэмшүүлэх цирк нь циркийн урлагт суурилсан нийгмийн оролцооны шинэ хандлага юм. Үүний зорилтот бүлэг нь гудамжны, орон гэрээсээ дайжсан болон цагдан хоригдож буй залуу үеийнхэн, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд зэрэг хувийн амьдралын болон нийгмийн эрсдэлтэй, баталгаагүй нөхцөлд амьдарч буй янз бүрийн хүмүүс байдаг.

Энэхүү шинэ хандлагын эн тэргүүний зорилго нь оролцогчдыг циркийн урлагт сургах биш харин циркээр дамжуулан тэдний өөрийгөө-үнэлэх үнэлэмж, бусдад итгэх итгэлийг нь дэмжин тэтгэж, нийгмийн амьдралд оролцох ур чадварыг нь дээшлүүлэх, нийгмийн идэвхтэй иргэн байж, бүтээлч сэтгэлгээгээ илэрхийлэх болон өөрсдийн нөөц чадамжийг нээхэд тусалснаар тэдний хувь хүний болон нийгмийн хөгжилд дэмжлэг тусалцаа үзүүлэхийг зорино.

Нийгэмшүүлэх цирк нь нийгмийг өөрчлөх маш хүчтэй хөшүүрэг юм. Учир нь энэ аргын тусламжтайгаар нийгэмд гадуурхагдсан хүмүүст нийгэм дэх байр сууриа олоход нь тусалдаг ба тухайн орон нутгийг ч тэрхүү хүмүүсийн авьяас чадвараар илүү баяжуулж өгдөг гэдгийг ойлгуулдаг юм.



НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРКИЙН ЗАРЧМУУД

1. Аюулгүй бас хөгжилтэй орчин




2. Олон нийттэй харилцах холбоо сүлжээ



3. Өөрийгөө илэрхийлэх ба бүтээлч байдал



4. Нийгэм ба цирк хоорондын хамтын ажиллагаа



5. Цагийн эрхэн дэх үргэлжлэх хугацаа



6. Оролцогч төвтэй хандлага



7. Түншлэл, хамтын ажиллагаа





Нийгэмшүүлэх цирк нь циркийн урлагт суурилсан нийгмийн оролцооны шинэ хандлага юм.

Нийгэмшүүлэх цирк нь циркийн жүжигчид болон нийгмийн ажилтнуудын чадварыг ашигладаг.

Нийгэмшүүлэх цирк нь хүүхэд залуучууд болон олон нийтийн хүрээнд өөрчлөлт гаргах асар том чадамж бололцоо юм.

Хувь хүний болон нийгмийн хөгжил нь нийгэмшүүлэх циркийн эн тэргүүний зорилго юм.



ХАРИЛЦАА ХОЛБОО

ЗОРИЛТ

Энэхүү бүлгийн төгсгөлд сургагч багш болон нийгмийн ажилтан нар дараах чадвартай болсон байна:

1. Харилцааны гурван бүрэлдэхүүн хэсэг болох - аман буюу үгээ хэрхэн сонгох, паравербал буюу хэлж буй ярианы дууны өнгө аяс болон биеийн хэл - ний талаарх ойлголттой болно.
2. Мэдээллийг зөв зохистой дамжуулахын тулд харилцааны техникт суралцсан байна.
3. Тодорхой ойлголттой болсноор бүтээлч хариу санал өгөхөд туслана.
4. Өөрийгөө илэрхийлэх, гол төлөв бусдыг сонсоход харилцааны чадвараа хэрэглэнэ.

Би Монголд нэг орчуулагчтай ажиллаж байлаа. Эхэндээ би Хойд Америкт ярьдаг шигээ ярихад орчуулагч маань миний хэлснийг орчуулахад ихээхэн хүндрэлтэй байгааг ойлголоо. Тэгээд бид сууж ярилцахад тэрээр “Та маш богино өгүүлбэрт багтаан ярьж мөн гол хэлэх санаагаа шууд хэлэх хэрэгтэй байна.” гэж хэлэв. Тэрээр Монгол хэлний өгүүлбэр зүй нь Англи хэлнийхээс маш өөр гэж тайлбарлалаа. Хэрэв би буруу санаагүй бол Монгол хэлний өгүүлбэр нь үйл үгээр эхэлж, нэр үг, тусагдахуунаар үргэлжилдэг. Тиймээс би үүнд зохицож, гол санаагаа аль болох товч тодорхой байдлаар илэрхийлж, илүү бага ярих болов. Энэ нь надад маш том хичээл болсон. Би Канадад буцаж очоод хүүхэд залуучуудтай харилцахдаа харилцааны энэхүү арга барилаа үргэлжлүүлэн ашигладаг болсон бөгөөд тэр ч байтугай Францад ч хэрэглэж байгаа.

Эммануэл Бошу, Нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагч
Cirque du Soleil буюу Нарны Цирк, Монтреал хот





ХАРИЛЦАА ХОЛБООНЫ АРГА ХЭРЭГСЭЛ

Сургагч багш нар аль эсвэл нийгмийн ажилтнууд хувь болон хэсэг бүлэг хүмүүстэй харилцаж байхдаа тэд дамжуулагч, хүлээн авагчийн үүрэг гүйцэтгэдэг аль эсвэл хоёуланг нь зэрэг гүйцэтгэдэг. Нүүр тулсан уулзалтад буй дамжуулагчийн хувьд, түлхүүр мессежээ илгээх гурван арга бий. Хамгийн үр нөлөөтэй мессеж нь илэрхийллийн доорх гурван хэлбэрийн хоорондын тэнцвэрийг хамгийн сайж барьж байгаа мессеж юм.

1. АМАН ИЛЭРХИЙЛЭЛ: ҮГ

Бидний хэрэглэдэг үг “аман илэрхийлэл” гэх зүйлийг бий болгодог. Үүнд үгийн сан, хэлзүйн дүрмийн бүтэц болон тусгай бүлэг хүмүүсийн хэрэглэдэг тодорхой ярианы хэллэг орно.

2. ДУУ ХООЛОЙНЫ ИЛЭРХИЙЛЭЛ: ДУУНЫ ӨНГӨ

Дуу хоолойны илэрхийлэл гэж үгийг хэрхэн дуудаж байгааг хэлнэ. Тухайлбал дууны өнгө, хүчдэл, зогсолт, дуудлага, дууны өнгө шилжүүлэг, үгийн өргөлт гэх мэт зүйлс багтана.

3. БИЕИЙН ХЭЛНИЙ ИЛЭРХИЙЛЭЛ : БИЕ

Харилцааны энэ хэлбэр нь гол төлөв нүүрний хувирал, биеийн хөдөлгөөн, биеийн байдал, нүдээр харилцах, орон зайн баримжаа (энэ нь яригч болон сонсогчдын хоорондын зай), болон түүнчлэн хувцаслалтын хэв маяг ч орно.





ҮР ДҮНТЭЙ ХАРИЛЦААНД ЗОРИУЛСАН АРГА ТЕХНИК

1. Юу хэлж ярихаа бэлд

2. Хэрхэн сонсохоо урьдаар мэд

3. Тухайн утгыг өөр үгээр хэлэх

4. Сонсогчдын үг хэллэгт дасан зохицох

5. Харилцаан дахь албан ба албан бус орон зайг тодорхойлох

6. Анхаарлыг хэрхэн татаж, цааш хэвээр байлгахыг мэдэж авах



ХАРИУ САНАЛ: АНХААРАЛДАА АВАХ ЗҮЙЛС

Хариу санал хэлэх үед хэд хэдэн зүйлийг анхаарах хэрэгтэй.

- Хариу санал нь тодорхой байх ёстой бөгөөд тухайлсан нөхцөл байдал аль эсвэл дохио зангааны талаар байх ёстой. Хариу санал нь гэхдээ ерөнхий зан авир, шинж байдлын талаар байж болохгүй.
- Хариу санал нь өөрчлөгдөж болохуйц шинж байдлын талаар ярих ёстой. Үр дүнтэй байх үүднээс хариу санал нь хялбархан өөрчлөгдөж болохуйц шинж байдлын талаар ярих хэрэгтэй. Харин тухайн хувь хүний төрөлхийн онцлог, аль эсвэл бие эрхтний гадаад үзэмжийн салшгүй хэсэг болсон шинж байдлын талаар ярьж болохгүй.
- Хариу санал нь эерэг аль эсвэл сөрөг байдаг. Хариу санал хэлэхдээ бусдад туслах явдал гол зорилго гэдгийг санах нь чухал.
- Хариу санал өгөхийн өмнө, харилцагчтайгаа итгэл үнэмшил, харилцан бие биеэ хүндэтгэх уур амьсгалыг бүрдүүлэх нь чухал. Тэднийг бид хүлээн авч, хүндэтгэж байна гэдгийг ойлгосны дараа л бид харилцагчдад хариу саналаа хэлэх хэрэгтэй.
- Хариу санал хэлэх талаар санал дэвшүүлж болохоос биш тулган хүлээлгэж болохгүй. Бид хариу саналыг зөвхөн хүлээн авахыг хүссэн хүнд л өгч болно.
- Хариу санал өгөхдөө, бид зөвхөн тухайн зүйлийн талаарх өөрсдийн үзэл бодлыг илэрхийлэх ёстой бөгөөд хэрхэвч багийн нэрийн өмнөөс ярьж буй дүр эсгэж болохгүй. Бид хүн бүхэнд өөрсдийн хариу санал хэлэхийг зөвшөөрөх бөгөөд тэр нь эерэг ч байж болно, сөрөг ч байж болно.
- Хариу санал нь нэг ёсны харилцаа холбооны хэлбэр бөгөөд энэ нь бүх соёлд нийтлэг биш юм. Тиймээс соёлын ялгааг танин мэдэх нь чухал.







Харилцаа холбооны сайн ур чадварыг хөгжүүлэх нь тэнхимд цугларсан хүмүүсийн анхаарлыг татахад тус болно.

Харилцан ярилцлага болон харилцагчийг анхааралтай сонсоход шаардлагатай цаг хугацааг зарцуулах нь эерэг харилцаа холбоог тогтооход тустай.

Өөрийн хэл яриаг тэнхим дэх сонсогчид хэвшүүлэн дасгах болон хүрээлэн буй орчин нэн чухал.

Харилцаа холбооны олон төрлийг (хараа, сонсгол, биеийн хөдөлгөөн) ашиглах нь янз бүрийн арга барилаар суралцдаг хүмүүстэй холбоо тогтооход дөхөм болно.

Утгыг өөрийн үгээр ярих нь нийтлэг болон хамтын ойлголтонд хүрэх үр дүнтэй хэлбэр юм.

Хэрхэн хариу санал өгөх болон хүлээж авах явдалд суралцах нь өв тэгш харилцааг хөхиүлэн дэмжих нэг ёсны харилцаа холбооны ур чадвар юм.



ЗӨРЧЛИЙН МЕНЕЖМЕНТ

ЗОРИЛТ

Энэхүү бүлгийн төгсгөлд сургагч багш болон нийгмийн ажилтан нар дараах чадвартай болсон байна:

1. Зөрчил маргааны бүрэлдэхүүн хэсгүүд болон түүний өрнөлийг ойлгох.
2. Зөрчил маргааныг зохицуулах, түүний үр нөлөөг арилгах, сулруулах талаар стратеги тодорхойлох.
3. Зөрчлийг шийдвэрлэх, мөн эвлэрүүлэн зуучлах арга замыг тогтоох.

Баг дотор ямар нэгэн зүйл болоод байгааг би совингоороо мэдмэгц, цаг гарган тэдэнтэй тухтай ярилцах нь надад чухал байдаг. Хэрэв хэн нэг нь сэтгэл санааны зовиуртай байвал, бид түүнтэй хамт сууж тухайн байдлаас гарах арга замыг хайна. Миний цуглар гэсэн зараар тэд ярилцах цаг болж гэдгийг шууд ойлгодог нь ч хэвшмэл болсон. Тэд нэг нэгэндээ багагүй тусалдаг бөгөөд би энэ асуудалд нь үе үе оролцдог. Бидний 11-р сард Монреал хотод болох тоглолтонд бэлтгэл хийж байх явцад баг дотор томоохон хямрал гарсан явдаг байв. Тэрээр хар тамхи татаж, пиво ууж байлаа. Үүнээс үүдэн бусад залуучууд түүнийг бэлтгэлд оролцуулахыг хүсэхгүй байлаа. Тэгэхэд би залуучуудад хандан, хэрэв бид түүнд туслахыг хүсч байгаа бол түүний уг байдлыг үл харгалзан хүлээн зөвшөөрөх ёстой гэж хэлсэн. Энэ тактик байр суурь залууд тус болж, тэрээр бэлтгэлд ирэх бүртээ бага багаар сайжирч, уухаа больсон. Харин үзүүлбэр эхлэхээс долоо хоногийн өмнө, багийн өөр залуу түүнд хандан, “Чи зүгээр л хар тамхичин” гэж хэлжээ. Залууд энэ үг таалагдаагүй бөгөөд уур амьсгал муудаж, хүн бүр циркээ орхихыг хүсч байлаа. Багийг гагцхүү би ганцаараа удирдаж байсан бөгөөд миний халамжинд 12 хүүхэд байв. Ийм байдалд би шантарч орхив. Эцэст нь би тэдэнд хандан, “Бид нэг зүйлийг эхлүүлсэн. Бид үнэхээр хамтдаа сайн үзүүлбэрийн эхийг тавьсан. Бид эцсийн эцэст энэхүү ажлаа хамтдаа дуусгах хэрэгтэй. Үүний дараа та бүгд өөрийн дуртай зүйлээ хийж болно, циркээ үргэлжлүүлэх үү, эсвэл циркээ орхих уу гэдэг та нарын хэрэг. Миний ганц та нараас хүсэх зүйл бол, өөрийнхээ эхлүүлсэн зүйлийг дуусгах ямар байдгийг та бүхнийг мэдээсэй гэж хүсч байна” гэж хэлсэн. Тэд хямралыг өөрсдөө даван туулж, улмаар ажлаа ч сайн хийж эхэлсэн. Би тэдэнд зөрчил маргааныг даван туулах арга барилыг зааж өгөхийг хичээж байгаа юм.



Алис Эшакуан, Тусгай Боловсролын Арга зүйч
Cirque du Monde буюу Дэлхийн Цирк, Манавэн



ЗӨРЧИЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Зөрчил бол нийгэм дэх амьдралын зайлшгүй нэг хэсэг: хүмүүс нэг нэгэнтэйгээ харилцаа холбоонд орж эхлэнгүүт л зөрчилдөөн гарч ирдэг нь тодорхой.

Зөрчлийг дор хаяж хоёр хүн аль эсвэл хоёр багийн хооронд гарсан нэг ёсны харилцан үл зөвшилцөл гэж тодорхойлж болох бөгөөд хоёр талд хамаарал бүхий аливаа зорилго, төсөл хөтөлбөр, нөөц бололцоо болон зан авирын талаарх тэдний ялгаатай үзэл бодол, сонирхол болон хүлээж авах хандлага зэргээс үүдэн маргаан бий болдог.

Зөрчил нь бодит аль эсвэл ёс төдий, хувийн аль эсвэл зайлшгүй чухал зүйл байж болно. Маргаан нь биет болон сэтгэл зүйн эсэргүүцлийн (заримдаа аюултай, тэр бүү хэл хүчирхийлэлийн) түвшинд хүргэж болно. Гэсэн хэдий ч зөрчилтэй нөхцөл байдлыг сөрөг зүйл гэж хүлээж авах шаардлагагүй; харин зөрчил нь зарим үед өөрчлөлт болон бүтээн байгуулалтын хүчтэй хөдөлгүүр болж чаддаг.

ЗӨРЧЛИЙГ ОЙЛГОХ НЬ

Хоёр талын хоорондын зөрчлийг ойлгох явдалд дараах зүйл орно:

1. Талууд нэг нэгнээсээ хэрхэн хамааралтай буйг ойлгох:

- Талууд нэг нэгэндээ хэр хэрэгтэй вэ?
- Нэг тал нь нөгөөгөө бодвол хэр их хүчтэй вэ?

2. Үл зохицолыг ойлгох нь:

- Яагаад хувийн зорилго зохицохгүй мэт санагддаг вэ?

3. Нийгмийн харилцан үйлдэлд зөрчил хэрхэн илэрч буйг ойлгох нь:

- Татагдан орсон талууд хэн бэ?
- Тэд ямар зан авир гаргасан бэ?
- Тэдний зан авир бусдад ямар нөлөө үзүүлдэг вэ?





ЗӨРЧЛИЙН ТӨРӨЛ

Сургагч багш нар болон нийгмийн ажилтнууд хоёр төрлийн зөрчилтэй тулгардаг. Энэ нь хувь хүмүүсийн хоорондын болон багийн хоорондын зөрчил юм. Нийгэмшүүлэх циркийн хувьд, эдгээр зөрчил нь дараах гурван нөхцөл байдлын нэгд нь илэрнэ.

Дэмжлэг туслалцааны хос баг болон оролцогчид хороондын зөрчил, аль эсвэл оролцогчид хоорондын зөрчил

Нийгэмшүүлэх циркийн сургагч багш нар ба нийгмийн ажилтнууд нь нийгмийн янз бүрийн гарал үүсэлтэй оролцогч охид хөвгүүдийн аль алинтай нь ажиллах үүрэгтэй. Эрсдэлд буй хувь хүмүүсийн багтай ажиллаж байхад зөрчил гарах нь гарцаагүй. Зарим онцгой тохиолдолд, эдгээр хувь хүмүүс үймээн самуун дэгдээж, нийгмийн эсрэг хэрцгий зан үйлдэл хүртэл гаргана. Тухайн бүлгийн үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах үүднээс сургагч багш болон нийгмийн ажилтан багийн менежментын стратеги (хэрэв зохистой бол) хэрэглэж, аль эсвэл хэрэгт хамрагдсан оролцогчидтой биечлэн уулзаж эдгээр зөрчлийг шийдвэрлэх ёстой.

Дэмжлэг туслалцааны хос багийн гишүүдийн хоорондын зөрчил

Дэмжлэг туслалцааны багийг бүрдүүлэхэд сургагч багш нар болон нийгмийн ажилтнууд өөр өөрсдийн үүргийн талаар хувийн үзэл бодолтой ирж, тус тусын арга барил, хандлагыг илэрхийлнэ.

Ярилцлагын явцад тэд эдгээр үзэл бодлоо хуваалцдаг бөгөөд энэ нь гол зорилгод хүрэхэд маш чухал үүрэгтэй. Нөгөөтэйгүүр, тухайн үзэл бодлоо зөрчил маргааны үед илэрхийлж болох бөгөөд, учир нь хүмүүс ихэнхдээ өөрийн санааг зөв, бүрэн зөв гэдэгт итгэлтэй байдаг юм. Тийм учраас хурцадмал байдлыг намжаахын тулд эдгээр үзэл бодол, хандлагаа нийцүүлэх арга замыг хайх нь чухал.

Байгууллагатай зөрчилдөх нь

Тухайн байгууллагад ажилтнаар орсон сургагч багш болон нийгмийн ажилтан нь үйл ойлголцох байдал, үзэл бодлын ялгаанаас болж зөрчилдөөнтэй тулгардаг.

Ажлын үйл ажиллагааны хүрээ, даалгавар, тэр ч байтугай хувь хүний үүрэг рольтой хамааралтай тодорхой буй байдлаас болж зөрчил гарч болно.

Мөн дэвшүүлсэн зорилго болон үнэт зүйлсийн үл зохицох байдлаас ч зөрчил гарч болно. Эцэст нь хэлэхэд, хэрэв аливаа хүндлэл, эргэцүүлэх явдал үгүй, харилцаа холбоо сул, мөн хурцадмал байдлыг сарниулах механизм байхгүй бол зөрчил улам хурцадмал байдалд орно.





ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ЯАЖ ХӨНДЛӨНГӨӨС ОРОЛЦОХ ВЭ

Багийн зөрчил гарахад, сургагч багш нар болон нийгмийн ажилтнууд зөрчлийг шийдвэрлэх зохистой шийдэл олохын тулд тухайн асуудалд идэвхитэй оролцох хэрэгтэй. Энэ шийдэл нь дандаа түргэн хялбар гардаггүй, тиймээс хүн бүр урагш тэмүүлж, суралцахад дөхөм болох чухал шийдвэр олоход анхаарах хэрэгтэй. Зөрчлийг шийдэх хэд хэдэн зүйл байж болно: жишээ нь, талуудыг эвлэрүүлэх, эсвэл багийн цаашдын ажлыг үргэлжлүүлэх боломжийг бий болгох буулт аль эсвэл шийдвэрийг олж хайх. Сургагч багш нар болон нийгмийн ажилтнууд нь багийн тогтвортой байдлыг хадгалахын тулд эвлэрүүлэн зуучлагчын үүрэг гүйцэтгэх хэрэгтэй болдог.

Зөрчлийн нөхцөл байдалд хэрхэн хандах тухай ерөнхий зөвшилцөл байдаг. Ийм алхам нь гурван үе шаттай хэрэгжинэ. Зөрчлийг эвлэрүүлэн зуучлах аргаар шийдвэрлэх тухай үе шат болгоны талаар нарийвчлан дор дурдсан байгаа.

1 дүгээр үе шат: Нөхцөл байдлын талаарх хувийн байр суурийг илтгэх

- Талууд нөхцөл байдлын талаар өөрийн үзэл бодлоо илтгэх ёстой. Тухайлбал, ажиглалт хийж болохуйц баримт нотолгоог танилцуулж, тэдэнд нөлөөлж буй үр дагаврууд, хэрэг байдлын талаарх хувийн тайлбар, мөн асуудлыг шийдэхийн тулд авч хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагыг тайлбарлах хэрэгтэй.
- Тал тус бүр нөхцөл байдлын талаарх бусдын саналыг анхааралтай сонсох хэрэгтэй.

2 дугаар үе шат: Харилцан ойлголцолыг тогтоох

- Талууд бусдын асуудлыг хэрхэн ойлгож буйгаа өөрийн үгээр тайлбарлах.
- Санал хэлэлцүүлгийн явцад талуудын байр суурь тодорхой болж ирнэ.
- Ташаа ойлголт гарах үед тухайн санааг өөр үгээр тайлбарлах нь чухал байдаг.

3 дугаар үе шат: Шийдлийг эрэлхийлэх

- Талууд хэд хэдэн боломжит шийдвэр дэвшүүлэнэ (арга барил, сахилга батын дүрэм зэрэг).
- Талууд боломжит саналуудад үнэлгээ хийж, ирээдүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хамгийн тохиромжтой шийдлийг тодорхойлно.
- Хамгийн зөв шийдэл нь хүлээн зөвшөөрөгдөж яваандаа хэрэгжих болно.

Энэхүү үйл явцын туршид, нөгөө талруугаа давшилахын оронд тал тус бүр тулгараад буй гол асуудал дээрээ анхаарах хэрэгтэй. Одоогийн нөхцөл байдлын талаарх ойлголтыг сайжруулах гээгүй бол өнгөрсний талаарх үг цухуйлгах хэрэггүй. Дэвшүүлж буй санал нь ажиглаж болохуйц шинж байдлын талаар байх хэрэгтэй. Түүнчлэн тал бүр өөрийн хэлж буй санаатай нийцэх биеийн хэл ашиглах ёстой. Хэрэв хэлэлцүүлэг нь хурцдаж эхэлвэл уулзалтыг хойшлуулах хэрэгтэй.

Notes 



ЗӨРЧЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ

Зөрчлийг шийдэх үйл явцад хүргэх сэтгэлд нийцэх дараах өөр өөр шийдлүүд байж болно. Үүнд:

- 1.Талууд харилцан тэгш буулт хийх замаар эвлэрэн зөвшилцөнө.
- 2.Талууд өөрийн байр суурь дээр бат зогсох боловч, тэдний сонирхол нийцэх нийтлэг үндэслэл олсон.
- 3.Талууд нэг нэгэнтэйгээ дайсагнах байдалтай байх боловч, ажиллаж болохуйц ажлын уур амьсгалыг дахин бий болгоно.
- 4.Талууд хүчээр тулган хүлээлгэсэн шийдвэрийг хүлээн авна; талууд аль аль нь хэрэг дээр ялагдах боловч, төсөл нь үргэлжилж болно.

Зөрчил үү аль эсвэл хямралын нөхцөл байдал уу?

Нийгэмшүүлэх циркийн бэлтгэл сургалтын явцад янз бүрийн шалтгааны улмаас оролцогчдын хооронд зөрчил үүсдэг. Энэхүү гарын авлагад тусгасан зөрчлийн менежментийн аргачилал нь ихэнх зөрчлийг шийдвэрлэхэд дөхөмтэй. Гэсэн хэдий ч тодорхой хямралын нөхцөл байдал нь сургагч багш болон нийгмийн ажилтны мэдлэг чадвараас хэтэрсэн хөндлөнгийн оролцоог шаарддаг. Тухайлбал, хордлого авах тохиолдол, сэтгэл мэдрэлийн хямрал, амиа хорлох гэсэн бодол, хууль бус үйлдэл, сэтгэл санааны болон бэлгийн дарамт, хэл үгээр доромжлох явдал, тэр ч байтугай гэмт хэргийн бүлэглэл оролцсон зөрчил орно.

Сургагч багш нар болон нийгмийн ажилтнууд зөрчилд орсон хүмүүст туслах хүсэл эрмэлзэл буй хэдий ч, тэд өөрийн мэдлээс хэтэрсэн нөхцөл байдлыг ойлгон, тодорхой хямрал, зөрчлийн асуудлыг шийдвэрлэдэг тусгай мэргэжилтэн аль эсвэл яаралтай эмнэлгийн тусламж үйлчилгээ бүхий нөөц бололцоотой газартай холбоо барих хэрэгтэй.

Notes 





Зөрчилд үргэлж хоёр тал оролцдог: хариуцлагыг хэзээ ч нэг тал үүрэхгүй.

Сургагч багш болон нийгмийн ажилтны үүрэг бол шуурхай хялбар шийдлийг олох бус харин хүн бүрт суралцах боломжоор хангах хамгийн зохистой шийдлийг олох явдал юм.

Зөрчил үүсгэхгүй байхын тулд хүч зарцуулах нь зарим үед зөрчлийг шийдвэрлэхэд шаардагдах хүч гаргахаас дээр байдаг.

Зөрчлийг шийдвэрлэж байх үед хоёр тал хоёул оролцож, сайн итгэл үнэмшлээ харуулах ёстой.



ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦАА БА БАГИЙН МЕНЕЖМЕНТ

Зорилт

Энэхүү бүлгийн төгсгөлд сургагч багш болон нийгмийн ажилтан нар дараах чадвартай болсон байна:

1. Өөрсдийн хүч чадлыг тодорхойлж, мөн сайжруулах шаардлагатай зүйлсээ ч тодорхойлно.
2. Эрч хүчтэй багийг бий болгох элементүүдийг танин мэдэх.
3. Баг удирдах стратеги тодорхойлж, харилцан үйлдлийг дэмжих.
4. Баг дотор бие даан зохицуулах уур амьсгалд түлхэц болохуйц элементүүдийг тогтоох.

Нэгэн өвөл би анх удаа Манаван дахь Атимекв хамт олныг зорьсон юм. Бидэнтэй уулзах ёстой байсан нийгмийн ажилтан ирээгүй бөгөөд учир нь тус хамт олон дотор амиа хорлох хэрэг гарсан байв. Бид ямарч байсан сургалтаа хийдгээрээ хийж, хүүхдүүдийг идэвхтэй байлгаж тэр хэргийн талаарх бодлыг нь сарниулахаар шийдсэн билээ. Туслах бид хоёр удалгүй гимназтикийн сургууль дээр очиж, 40 залуу үеийнхний өмнө зогсож байлаа. Тэд бүгд сууж байсан бөгөөд зөвхөн Атикамекв хэлээр ярьж, биднийг шоолж инээн мөн гутлаа тайлахаас татгалзаж байв. Тэд мэдээж биднийг шалгаж, туршиж байсан. Тэдний гутлыг нь тайлуулах гэж 30 минут болов. Бид тэдний удирдагчийг нь хэн гэдгийг олж, түүнийг гутлаа тайлахыг нь ятгав. Тэр гутлаа тайлмагц 2 секундэн дараа бусад нь бүгд мөн гутлаа тайлцаасан. Энэ үйлдэл агшин зуур болж өнгөрөв. Ихэнх тохиолдолд тухайн бүлгийн удирдагчийг ятгаж ойлгуулах нь эерэг үр дүн авчирдаг.




Карин Лавой, Нийгэмшүүлэх Циркийн зааварлагч
Cirque du Monde буюу Дэлхийн Цирк, Монреал



ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦААНЫ ГУРВАЛЖИН

Оролцогчдын багт дэмжлэг туслалцаа үзүүлж буй сургагч багш нар болон нийгмийн ажилтнуудын гол үүрэг бол тухайн багийг аажмаар хөгжин дэвжих, өөртөө хариуцлага хүлээх явдалд сургах явдал юм. Оролцогчдын хөгжилд тус дөхөм болох шаардлагатай мэдлэг өгөхөд нэн тохиромжтой нөхцөл бүрдүүлэхийн тулд сургагч багш нар, нийгмийн ажилтнууд нь мэдлэг чадвараа хуваалцахад дөхөмтэй, баг дотор нийгмийн үр нөлөөтөй уур амьсгалд мэдрэмжтэй байх дүрэм журмыг баталж, агуулгыг анхааралтай төлөвлөх ёстой.

ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦААНЫ ГУРВАЛЖИН



• Агуулга

Багийн мөрдөж буй зорилго нь бат бэх байдлыг хөхиүлэн дэмжиж, тэмүүлэл хөгжлийн гол хөдөлгөгч хүч болдог. Сургагч багш болон нийгмийн ажилтнууд дасгал хичээл, үзэл санаагаа зөвөөр илэрхийлж, бүх гишүүдэд ойлгуулах явдлыг хангах хэрэгтэй. Үүний тулд, тэд дараах зүйлд хариуцлага хүлээх ёстой:

- Агуулгыг тогтоох
- Агуулгыг бүгдэд хүртээмжтэй болгох
- Зөвшилцөл бий болгох
- Олж авсан мэдлэг, сургамж, санал онолыг нэгтгэж, дүгнэх

• Дүрэм журам

Багийн зорилгод хүрэхэд дөхөм батлагдсан арга барил, дүрэм журам нь тодорхой байх ёстой бөгөөд багийн бүх гишүүд үүнийг хүлээн зөвшөөрсөн байх ёстой. Сургагч багш болон нийгмийн ажилтан дараах зүйлд хариуцлага хүлээнэ:

- Хамтын оролцоог хөхиүлэн дэмжих
- Асуудал хурцдах үед тухайн байдлыг дарах
- Цагийн зохицуулалт хийх



- Хувь хүний оролцоог дэмжих

- Багийн уур амьсгал (багийн нийгмийн үр дүнтэй тал)

Сургагч багш болон нийгмийн ажилтан нь багийн сэтгэл санааны байдалд мэдрэмжтэй байх ёстой. Тэдний үүрэг нь илүү сайн суралцах болон хөгжлийг бий болгох нийгмийн үр дүнтэй эерэг уур амьсгалыг багийн төлөө бүрдүүлэх явдал юм. Багийн гишүүдтэй сэтгэл санааны талаарх илэн далангүй яриа өрнүүлж, гишүүдийн зан үйлдлийн ялгааг ойлгох замаар сургагч багш болон нийгмийн ажилтан нь нааштай уур амьсгал тогтооно. Ялангуяа, тэд дараах зүйлд хариуцлага хүлээнэ:

- Оролцогчдын хувийн амьдралд сонирхол хандуулснаар тэд оролцогчдыг найрсаар угтан авахад
- Албан болон албан бус үед амар амгалан байдал, эв санааг хөхиүлэн дэмжих
- Үзэл санаа, тавгүй байдалд бодитой хандах
- Саад бэрхшээл, дургүйцлийг дуу хоолойгоор илэрхийлэ



Notes 

Lined writing area with 26 horizontal blue lines.



ЗАН ҮЙЛИЙН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Доорх хүснэгтэд янз бүрийн хувь хүний зан үйлийн тулгамдсан асуудлуудыг тодорхойлсон.

Эдгээр зан үйлийн тулгамдсан асуудлууд нь тухайн багийн хөгжил, бүтээн байгуулалт, зорилгод хүрэх замд саад тотгор учруулдаг. Тийм учраас ийм төрлийн зан үйлдлийг багийн бусад гишүүд голдуу шүүмжлэлтэй хүлээж авдаг. Эрт орой хэзээ нэгэн цагт, ийм зан үйлдэл гаргасан гишүүдийг бусад гишүүд үл тоож, хайхрахгүй болно. Хэрэв багийн зүгээс зохих зэвүүцэх хандлагаа илэрхийлж, улмаар тэдгээр гишүүдийг ямар ч чадваргүй гэж үзээгүй л юм бол.

Ийм зан үйлдэл илрэх үед, багш гол үүрэг гүйцэтгэж, бусад гишүүдэд илүү баялаг аргаар үйл явцад оролцох боломж олгох ул суурьтай ярилцлага өрнүүлэх хэрэгтэй. Энэ нь юу гэсэн үг гэвэл, зарим гишүүдийн эзэлсэн орон зайг багасгах үүднээс зарим үед цөөн бүлэг хүмүүс дотор идэвхитэй үйл ажиллагаа өрнүүлж, мөн тодорхой хугацаанд хүн тус бүрт онцгой анхаарал хандуулах явдал юм. Бусад тохиолдолд, асуудалд оролцсон багийн гишүүдийн үзэл бодолтой зөрчилдөхгүй, аль эсвэл тэднийг бусад гишүүдийн өмнө үл тоомсорлохгүй байх тал дээр анхаарын хажуугаар саналаа илэрхийлэх нь илүү тохиромжтой байж болно. Жишээлбэл: “Таны санал сонирхолтой байна гэхдээ бусад нь энэ тал дээр юу гэж бодож байгааг бас мэдмээр байна”; “Миний бодлоор та энэ санал дээр хатуу байр суурьтай байгаа бөгөөд та бусдыг ч гэсэн тантай санал нийлээсэй гэж хүсч байгаа юм байна, гэхдээ би уг асуудлын талаар өөр үзэл бодол сонсмоор байна”; эсвэл “Яриа хэлэлцлэг үнэн хэрэгтээ удааширч байгаа юм шиг байна. Хэн нэг нь үр бүтээлч санал гаргаж, асуудлыг дахин сэргээж хэлэлцэх үү?” гэх мэт.

Хувь хүмүүсийн зан үйлийн тулгамдсан асуудлууд ба дүр төрхийн ангилал

Ангилал	Дүр төрх	Тодорхойлолт	Хөндлөнги
Биеэ барьсан	Хоосон ярьдаг, чалчаа	Хашгирсан, зогсолтгүй ярьдаг	
	Сатааруулагч	Ярианаас холбирдог, ярианы сэдвээ огцом өөрчилдөг	
	Яаруу, тэвдүү	Хэт нарийн асуудалд гацдаг	
	Алиалагч	Бүх чухал сэдвээс зайласхийсэн, бүх юмыг тоглоом болгон эргүүлдэг	
	Мэргэжилтэн	Бүхнийг мэдэгч шиг аашилдаг	
Сөрөг талууд	Илжиг шиг зөрүүд	Үзэл бодлоо хөдлөшгүй баримталдаг	
	Эсэргүүцэгч	Зогсолтгүй шүүмжилдэг	
	Хатуу хүчтэй	Саналаа тулган хүлээлгэдэг, бүхнийг	
	Харгис догшин	Дайсагнах уур амьсгалыг бага багаар бий болгодог	
Хөндий байх, хөндлөнгөөс ажиглах	Гутранги байх	Үл зөвшилцөлөөс болж юм ярихгүй	
	Бусдыг зүгээр хараад суусан, юу ч хийдэггүй	Өөртөө итгэлгүй	
Ямар ч ач холбогдолгүй	Дээгүүр зантай, хамраа сөхсөн	Ярилцлагыг үл сонирхсон	
	Эвшээж суусан	Дульхан, тааруухан	
	Аялдан дагалдагч	Хувийн үзэл бодолгүй	



ЧИГЛҮҮЛЭГЧИЙН АЖИГЛАЛТЫН ХҮСНЭГТ

Дэмжин туслах зүйл бүр дээр таны үнэлгээг хамгийн сайн илэрхийлэх дугаарыг дугуйлна уу.

	Үл тохирох	Хангалтгүй	Сул	Сайн	Маш сайн	Онц
ҮГ ХЭЛИЙН ХАРИЛЦАА ХОЛБОО						
Тодорхой, нягт нарийн тайлбар	Ү/т	1	2	3	4	5
Тусламж дэмжлэгийн үед хөндлөнгөөс оролцох	Ү/т	1	2	3	4	5
АМАН ХАРИЛЦАА ХОЛБОО						
Дуу хоолойн өнгө аяс	Ү/т	1	2	3	4	5
Илтгэлийн хэмнэл	Ү/т	1	2	3	4	5
АМАН БУС ХАРИЛЦАА ХОЛБОО						
Биеэр байлцах	Ү/т	1	2	3	4	5
Дохио зангаа	Ү/т	1	2	3	4	5
Нүдээр харьцах	Ү/т	1	2	3	4	5
ХУВЬ ХҮМҮҮСИЙН ХООРОНДЫН ЗАН ҮЙЛДЭЛ						
Дэмжин туслах зорилтыг ижил тэгш хуваах	Ү/т	1	2	3	4	5
Багт дасан зохицох чадвар	Ү/т	1	2	3	4	5
Итгэлцэх барилдлага бий болгох чадвар	Ү/т	1	2	3	4	5
ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦААНЫ БҮТЭЦ						
Оршил	Ү/т	1	2	3	4	5
Дэс дараалал	Ү/т	1	2	3	4	5
Дүгнэлт	Ү/т	1	2	3	4	5
Үнэлгээ	Ү/т	1	2	3	4	5
Цагийн менежмент	Ү/т	1	2	3	4	5

Тайлбар

Дэмжлэг тусалцааны талаарх надад таалагдсан хоёр зүйл:

Сайжруулах хэрэгтэй хоёр талбар





Хослон заах стратегийг ашиглах нь багийн идэвхитэй үйл ажиллагааг бий болгох, дэмжихэд таатай нөлөөлнө.

Хүнд нөхцөл байдалтай тулгарах үед оролцогчид хоорондын зөрчил, багийн идэвхтэй үйл ажиллагааг сулруулах явдлаас урьдчилан сэргийлэхийн тулд сургагч багш нар болон нийгмийн ажилтнууд түргэн шуурхай хариу авах хэрэгтэй.

Хослон заах үед, агуулга, үйл явц, уур амьсгал бүрт анхаарлаа адил тэгш хандуулах ёстой.

Баг тус бүрийн хөгжлийн хурдац, соёлыг хүндэтгэх нь чухал.



СОЁЛ ХООРОНДЫН ХАРИЛЦАА

ЗОРИЛТ

Энэхүү бүлгийн төгсгөлд сургагч багш болон нийгмийн ажилтан нар дараах чадвартай болсон байна:

1. Соёл хоорондын харилцаа холбоог хөхиүлэн дэмжих авьяас чадварыг таньж мэдэх.
2. Нийгэмшүүлэх циркийн хөтөлбөрийг соёлын агуулганд тохируулах.
3. Хөндлөнгийн оролцооны үед тухайн багт илэрсэн соёлын бодит байдалд илүү зохицох, илүү ойлгох арга хэрэгслийг олох.

Zip Zap Bong гэх нэртэй нэг тоглоом байдаг юм. Ухаанаа төвлөрүүлэх шаардлагатай энэхүү тоглоомд та өөр дүрэм нэмж оруулж болно. Би Диско Диско Тайм гэх нэртэй тоглоом нэмж оруулсан: тоглоомын үед ямар нэг оролцогч алдаа гаргахад, бусад нь алга ташиж, хөлөө дэвсэн, “Диско, диско, диско тайм” гэж дуулна. Алдаа хийсэн оролцогч тойргийн голд орж, бүжгийн ямар нэг хөдөлгөөн хийнэ. Ерөнхийд нь хэлэхэд, энэ нь залуучуудыг илүү төвлөрөхөд тус болох бөгөөд учир нь төвлөрөөгүйн улмаас алдаа гаргаж хүн бүхний өмнө бүжиглэхийг хэн ч хүсэхгүй шүү дээ. Энэ тоглоом нь Европ болон Хойт Америкад үнэхээр сайн үр дүн өгдөг. Гэвч Бразилд үгүй юм байна!

Бразил залуучууд бүжиглэх маш дуртай тул тэдний хувьд энэ нь шагнал болох ба тэд өөрсдийнхөө бүжиглэж чаддагийг харуулахын тулд зориуд алдаа гаргадаг байв.

Эммануэль Бошу, Нийгэмшүүлэх Циркийн
Дасгалжуулагч
Cirque du Soleil буюу Нарны Цирк, Монтреал





НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРКИЙН ХҮРЭЭН ДЭХ СОЁЛ

Сургагч багш нар болон нийгмийн ажилтнууд нь өөрсдийнхөөс нь өөр, янз бүрийн нийгэм соёлын үүсэл гаралтай хамт олонтой ажиллах хэрэгтэй болдог бөгөөд соёл хоорондын харилцаа нь тэдний хувьд маш том сорилт болдог. Шинэ соёлыг танин мэдэх нь бид янз бүрийн арга барилаас суралцахад чиглүүлдэг бөгөөд цаашлаад энэ нь бид хэн болох, ямар хүн болохыг хүсч байгаагаа дахин тодорхойлоход хүргэдэг. Энэхүү үйл явцыг эхлүүлэхээс өмнө, соёлын мөн чанарыг ойлгох нь чухал юм.

Соёлыг тодорхойлох нь

Соёл гэдгийг хүний төрөлхийн бус зан чанарын багц зүйл, харин эдгээр зан чанарт нийгэмд амьдарч буй үедээ суралцдаг гэж тодорхойлж болно. Хэл гэх зарим шинж байдал болон ёс заншил зэрэг зүйлийг хялбархан ялгаж таниж болох ч ертөнцийг үзэх үзэл, итгэл үнэмшил, үнэ цэнэ, сэтгэлгээ зэргийг ялган тодорхойлоход тийм ч хялбар биш. Гэсэн хэдий ч эдгээр тодорхойлоход хялбар биш зан соёл нь бидний аливаа зүйлийг хүлээн авах хандлагад шүүлтүүр мэт тогтмол нөлөөлж байдаг.

КОЛИЙН СОЁЛЫН МӨСӨН УУЛАН ЗАГВАР



СОЁЛ ХООРОНДЫН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ УР ЧАДВАР

Өнөөгийн дэлхий ертөнцөд, янз бүрийн соёл заншилтай хүмүүстэй хэрхэн харьцах тухай мэддэг байх нь маш хэрэгтэй зүйл болж байна. Ийм ур чадварт суралцахын тулд бид өөрсдийн оюун ухаан, бүтээлч ур чадвараа хөшүүрэг болгох ёстой бөгөөд мөн одоо бидний хэлэлцэх гэж буй зүйл дээр тодорхой үндсэн ур чадвараа ашиглах хэрэгтэй.

Өөрийгөө танин мэдэхэд суралцах:

- Өөрийн орны соёл болон бусдын соёлыг ч мөн адил таниж мэдэх.
- Та аливаа зүйлийг хэрхэн ойлгож, тайлбарладаг явдалд танай орны соёл хэрхэн нөлөөлж буйг ойлгох

Хэвшмэл ойлголтуудаас холхон байх:

- Бодит байдлыг та хэрхэн зөв хүлээн авдгаа үнэлэх.
- Ерөнхийлөн дүгнэх байдалд болгомжтой ханд: Тухайлбал, хэл ярианы дуудлага, арьсны өнгө зэрэг нь тодорхой зан үйлдэл, үнэт зүйлсийг илтгэж байна гэж бүү таамагла.

Гэнэтийн шүүмж, дүгнэлт гаргахаас зайлсхийх:

- Яаран дүгнэлтэд хүрэхийн өмнө тухайн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх цаг гарга.
- Ойлголтоо бататгахын тулд асуулт асууж, нэмэлт мэдээлэл олж хай.

Лавлагааны бусад баримтыг олж илрүүл:

- Бусдаас суралцахад нээлттэй бай.
- Соёл хоорондын харилцаа холбооны үед нэгээс илүү тайлбар мэдээ олж хай.

Харилцан тохиролцож сурах:

- Соёлын хоорондын ялгаатай зүйлд илүү анхаарч байснаас ижил төстөй зүйлийг нь олж харах.
- Талууд асуудлаас хол байх боломжийг олгох тайлбар олж хайх.
- Ялгаатай байдлыг шийдэх буулт хайхыг хичээх.

Харилцаа холбооны ур чадварыг хөгжүүлэх:

- Товч тодорхой, цэгцтэй, зохион байгуулалттай мэдээлэл боловсруулах.
- Мэдээлэлээ түгээхэд өөрийн дуу хоолой, мөн биеийн хэлийг хэрхэн зөв ашиглах тал дээр суралцах.
- Түгээж буй аман болон бус мэдээлэлээ тайлбарлах.
- Харилцаа холбооны утга санааг анхаарах: тухайн агшин болон тухайн болж буй газарт анхаарах.

Харилцахдаа цаг гаргах:

- Янз бүрийн соёлын харилцааны хэмнэл, хэв маягийг хүндэтгэж сурах.
- Тэвчээртэй бай: соёл хоорондын харилцаанд хүрэхэд цаг хугацаа хүчтэй холбоотон болно.
- Эдгээр хувь хүмүүсийн нийгмийн ертөнцөд том үүрэг гүйцэтгэж буй хүмүүстэй холбоо тогтоохыг хичээх.





НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРК, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ БА СОЁЛЫГ ТЭТГЭН ДЭМЖИХ

Нийгэмшүүлэх циркийн бэлтгэл сургалтын явцад сургагч багш нар болон нийгмийн ажилтнууд эвлэрүүлж болох орон зайг бүрдүүлэх үүрэгтэй. Тэд оролцогчидтой харилцах бүртээ үлгэр жишээ үзүүлж, бусад соёлд нээлттэй байхыг дэмжиж, тэдгээрийн ялгааг хүлээн зөвшөөрч, (оролцогчид бодит байдлыг хүлээн зөвшөөрч буй нөхцөлд) мөн циркийн соёлыг ч бий болгохыг зөвшөөрөх хэрэгтэй. Нийгэмшүүлэх циркийн бэлтгэл сургалт нь оролцогчдод хэрхэн сониуч, бусдад нээлттэй байхыг зааж өгөх нэн зохистой боломжийг олгож, мөн янз бүрийн ялгаа онцлогоос үүдэн гарах бүтээлч байдлыг нээн илрүүлэхэд тус дөхөм болдог.

Notes 





Соёл болгон өөрийн дүрэм, журам, зохицуулалт болон эрхэмлэх үнэ цэнэтэй.

Нийгэмшүүлэх цирк нь хамран оролцох бололцоо ба соёлын нээлттэй байдлыг санал болгож болно. Өөрөөр хэлбэл, энд өөр өөр ялгаатай зүйлс нь нэгдсэн нэг зорилгод хүрдэг юм.

Сургагч багш нар болон нийгмийн ажилтнуудын хувьд өөрийн орны соёлын болон тэдэнтэй ажиллах бусад хамт олны соёлын зарчим, үнэ цэнийг танин мэдэх нь чухал юм.

Аливаа ялгаа, олон янзын шинж байдлыг хүлээн авахад бэлэн байна гэдэг нь соёлын, бие махбодийн, мэдлэг оюуны, нийгмийн, эдийн засгийн, угсаатны, хүйсийн, бэлгийн чиг хандлага болон бусад ялгаатай байдлыг хүлээн авахад бэлэн байна гэсэн үг билээ.



ТҮНШЛЭЛ

ЗОРИЛТ

Энэхүү бүлгийн төгсгөлд сургагч багш болон нийгмийн ажилтан нар дараах чадвартай болсон байна:

1. Түншлэлийн харилцаанд сургагч багш нар болон нийгмийн ажилтнуудын үүрэг хариуцлагыг тодорхойлох.
2. Түншлэлийн хүрээнд ажиллахад гарах ашиг тус ба сорилтыг танин мэдэх.

Бидний дөрвөн түнш болох: С.А.С.Т.У.С. Монреал, Ле Бон Дио дан ле рүи, Ан Марж 12-17 болон План Милюу –ны томоохон хамтын оролцоогүйгээр Монреалд Дэлхийн Цирк маань ийм гайхамшигтай амжилтанд хүрэхгүй байсан. Хэдийгээр эдгээр байгууллага нь өөр өөр хандлага, өөр үйлчлүүлэгч, үйл ажиллагааны өөр дүрэм журамтай ч тэд Дэлхийн Циркийн бэлтгэл сургалтанд нэгдсэн зарчмыг олж чадсан билээ. Тэдний оролцогчид нэгдсэн нэг баг бүрдүүлэхээр цугларч; бэлтгэл сургалтын заах цагийг нөхөн нийгмийн ажилтнууд нь бие биедээ дэмжлэг үзүүлж; хүн бүр тогтсон ёс журам дагахаар зөвшөөрч, тэр бүү хэл элсэлтийн нэгдсэн стратегийг боловсруулсан билээ. Товчхон хэлэхэд, бүх оролцогчид бэлтгэл сургалтыг сайн явуулахын тулд өөрсдийн нөөц бололцоог дайчилж, шаардлагатай буултыг хийсэн билээ. Эцэст нь, тэдний хийсэн эдгээр бүх ажлын үр дүнд нийгэмшүүлэх циркийн чанартай бэлтгэл сургалтаас залуучууд ашиг хүртэж чадсан юм.

Мишээл Лафортун,
Нийгэмшүүлэх Циркийн Захирал
Cirque du Soleil буюу Нарны Цирк, Монреал





ТҮНШЛЭЛИЙН ДАВУУ ТАЛ

Түншлэл нь олон давуу талтай. Кристофер Брайнт эдгээр давуу талыг нээж, бид түүний үзэл санааг нийгэмшүүлэх циркийн нөхцөлд хэрэгжүүлсэн:

1. Түншлэлийг нэмэгдүүлэх боломжтой гэдэг нь нөөц бололцоог нийлүүлнэ гэсэн үг юм.
2. Түншлэл нь төлөвлөсөн үйл ажиллагааны хүрээг нэмэгдүүлдэг.
3. Түншлэл нь хамт олны хөгжилд гишүүд нь илүү хариуцлагатай байх хэрэгтэй гэдгийг хүлээж авахыг сайшаадаг.
4. Түншлэл нь гайхалтай үр дүнд хүргэдэг, учир нь тэд нэг нэгнийхээ өөр өөр, нэмэлт үүргийг хүлээн зөвшөөрдөг.
5. Багаар ажиллах үед, түншлэл нь тухайн талуудад бусдын хөгжилд хувь нэмэр оруулах бололцоо олгодог.

ТҮНШЛЭЛИЙН СОРИЛТУУД

Түншлэл нь мөн тодорхой сорилтыг авчирдаг. Үүнд:

1. Зөвшилцөлд хүрэх, зөрчилдөөнтэй тулгарах нь заримд үед бэрхшээлтэй байдаг.
2. Цөөн бүлэг хүмүүс эрх мэдлийг дур мэдэн авах талтай байдаг.
3. Хүн бүр жигд хурдаар ажилладаггүй гэдгийг хүлээн зөвшөөрөх нь сэтгэл гонсойлгох талтай.
4. Өөрчлөлтийн найдвар горьдлого нь түгшил, зовнилийг бий болгож болно.
5. Мэдээллийн хүртээмжтэй байдлыг хянах, аль эсвэл мэдээлэл байхгүй байх.





АЛИВАА ТҮНШЛЭЛ АМЖИЛТТАЙ БОЛОХОД...

Аливаа түншлэлийн амжилтанд хүрэхэд хувь нэмэр оруулах ерөнхий хэдэн дүрэм бий. Үүнд:

1. Өөрийн үзэл бодлыг эхнээсээ тулган хүлээлгэхгүй байх.
2. Түншлэлийн гол анхаарах зүйл нь тухайн хамт олны ашиг сонирхолыг нэн тэргүүнд тавих гэдгийг мартаж болохгүй.
3. Нэгдсэн зорилгод хүрэхэд төлөвлөсөн үйл ажиллагаанууд хэрхэн тус болохыг ойлгомжтой тодорхойлох.
4. Түншүүдийн хариуцах үүрэг, зардал, ашиг, эрсдэл зэргийг ил тодоор тогтоох.
5. Ажил эхлүүлэхдээ уян хатан бус байр суурьтай байхаас зайлсхийх.
6. Урт хугацааны түншлэл тогтоохоос өмнө жижиг төсөл, бага амжилтаас эхэл.
7. Хөгжлийн үе шат бүрт харилцаа холбоог эн тэргүүнд тавих.
8. Бүх түншүүдийг байхад төлөвлөгөөгөө гаргах.
9. Хамтдаа үнэлгээ хийх.
10. Түншлэлийн хугацааг тогтмол үнэлж байх.
11. Амжилттай түншлэлийг бий болгоход ажилд оролцсон хувь хүмүүс гол үндэс гэдгийг мартаж болохгүй.

Notes 





Бат бэх түншлэл нь маш өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулах боломж олгодог.

Түншлэл нь оролцогч хоёр талын хувьд аль алинд нь ашигтай байх ёстой.

Аливаа түншлэлийн амжилтад нээлттэй бөгөөд хамтран ажиллах эрмэлзэлтэй хандлага нь маш чухал хүчин зүйлс юм.



ХАВСРАЛТ

НАРЫН ЦИРКИЙН НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРКИЙН ҮГ ХЭЛЛЭГ

Дараах үг хэллэг нь *Нарны Циркийн* хэрэглэж ирсэн нийгэмшүүлэх циркийн нэр томъёоны онцлогыг тайлбарлаж байгаа юм. Энэхүү тайлбар нь *Нарны Циркээс* гаргасан нийгэмшүүлэх циркийн талаарх бүх баримт материалд хэрэглэдэг нэр томъёо, үг хэллэгийн тухай ерөнхий ойлголтыг гаргаж ирнэ.

Эрсдэлд буй хувь хүмүүс

Нэг буюу түүнээс дээш аюулгүй байдлыг хангасан хүчин зүйлс нь хүний үндсэн эрхийг бүрэн дүүрэн эдлэхэд өөрийн үндсэн үүрэг хариуцлагыг хүлээн зөвшөөрөх боломжийг хангадаг. Харин нэг ба түүнээс дээш аюулгүй байдлыг хангасан хүчин зүйлсээ алдсан хувь хүмүүсийг эрсдэлд буй хувь хүмүүс гэнэ. Тэд ихэнхи тохиолдолд ядуурал болон сургалтаас завсардах зэрэг нийгэм-эдийн засгийн гачигдлын золиос болдог. Эдгээр хүмүүсийн ихэнхи нь нийгмийн болон гэр бүлийн тэнцвэртэй амьдралыг бий болгоход бэрхшээлтэй тулгардаг учир нь тэд гол төлөв нийгмийн аюулын эрмэгт амьдарч байдаг. Эрсдэлд буй хүн ам нь эмзэг сэтгэл зүйн болон биеийн эрүүл мэндээс болж шаналдаг. Мөн хар тамхи, архинд донтох нь ч олон байдаг.

Дэлхийн Цирк

“Нарны Цирк” болон эрсдэлд буй залуучуудыг зорилтот бүлгээ болгосон “Дэлхийн Залуучууд” нэртэй байгууллага нь 1995 онд нийгэмшүүлэх циркийн хөтөлбөрийг гаргажээ. “Дэлхийн Циркийн” сургалтын загварын дагуу нийгэмшүүлэх циркийн бэлтгэл сургалтыг орон нутгийн түншүүд зохион байгуулдаг бөгөөд тэдэнд “Нарны Циркээс” санхүүгийн, материаллаг (циркийн тоног төхөөрөмжийн хандив) болон зохион байгуулалтын дэмжлэг үзүүлдэг. Энэ дэмжлэгт түүнчлэн нийгэмшүүлэх циркийн сургагч багш нарыг ажилд авах болон тэднийг сургах ажил ч орно. “Нарны Цирк” нь нийгмийн янз бүрийн асуудлын бүгдийг шийдэх хэрэгсэл, аль эсвэл эрсдэлд буй залуучуудыг бодит байдлаас нь сатааруулж, цагийг өнгөрөөх цэлгэр том өрөө ч гэж зарлаагүй. Харин уг Цирк нь оролцогчид нь Канад, Бразил, Монгол аль эсвэл өөр улс орноос ч бай хамаагүй, зөвхөн тэдний амьдралын шинэ үе шат руу чиглүүлэх тулгуур болохыг л тэдэнд санал болгож байгаа билээ.

Мөрдөх ёс журам

Нийгэмшүүлэх циркийн улирал болгоны эхэнд хослон заах баг болон оролцогчдын ардчилсан хэлбэрээр хүлээн зөвшөөрсөн мөрдөх ёс журмын багц байна. Үүнийг бэлтгэл сургалтын жигд явуулах үүднээс батласан юм. Эдгээр дүрэм журамд сургалтын байр, тоног төхөөрөмж (агуулах, техник үйлчилгээ, засварын ажил, зээл, ашиглах материал), мөн хичээлийн хуваарь, аюулгүй байдлын журмыг тусгасан. Товчхондоо, мөрдөх ёс журам нь харилцан хүндэтгэх харилцаа холбооны суурийг тавьж, зөрчлөөс гарах үр дагаврыг тусгасан байдаг.

Түнш байгууллага (буюу орон нутгийн байгууллага)

Тухайн орон нутгийн байгууллага нь тэдний хамт олонд зориулсан нийгэмшүүлэх циркийн төслийн бэлтгэл ажил, төслийг хэрэгжүүлэхийг хариуцна.

Нийгэмшүүлэх цирк

Нийгэмшүүлэх цирк нь нийгэмд оролцох шинэ хандлага бөгөөд энэ нь циркийн урлагийг эрсдэлд буй хүмүүсийн хувь хүний болон нийгмийн хөгжлийг дэмжих хэрэгсэл болгон ашигладаг юм. Үүний зорилтот



бүлэг нь хувийн болон нийгмийн эрсдэлтэй, баталгаагүй нөхцөлд амьдарч буй янз бүрийн хүмүүс бөгөөд тухайлбал гудамжны болон цагдан хоригдож буй залуус, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд зэрэг орно. Энэхүү хандлагын анхдагч зорилго нь зөвхөн дан циркийн урлагт сургах явдал биш юм. Харин циркээр дамжуулан тэдний өөрийгөө-үнэлэх үнэлэмж, бусдад итгэх итгэлийг нь дэмжин тэтгэж, нийгмийн амьдралд оролцох ур чадварыг нь дээшлүүлэх, нийгмийн идэвхтэй иргэн байж, бүтээлч сэтгэлгээгээ илэрхийлэх болон өөрсдийн нөөц чадамжийг нээхэд тусалснаар тэдний хувь хүний болон нийгмийн хөгжилд дэмжлэг тусалцаа үзүүлэхийг зорино. Нийгэмшүүлэх цирк нь нийгмийг өөрчлөх маш хүчтэй хөшүүрэг бөгөөд учир нь нийгэмд гадуурхагдсан хүмүүст нийгэм дэх байр сууриа олоход нь тусалдаг ба тухайн орон нутгийг ч тэрхүү хүмүүсийн авьяас чадвараар илүү баяжуулж өгдөг гэдгийг ойлгуулдаг юм.

Нийгэмшүүлэх циркийн нийгмийн ажилтан

Нийгмийн хөндлөнгийн оролцогч мэргэжилтнүүд гол төлөв орон нутгийн байгууллагаас ирдэг. Тэдний гол үүрэг нь оролцогчидтой хамт нийгэмшүүлэх циркийн бэлтгэл сургалтанд хөндлөнгөөс оролцож, гишүүдийн хувийн болон нийгмийн хөгжлийн явцад зааварчилгаа өгөхөд оршино. Нийгэмшүүлэх циркийн нийгмийн ажилтан нь тухайн хамт олны дотор нийгэмшүүлэх циркийн төсөлд оролцогчдын сонирхлыг татах, тэдний дунд итгэлцлийн харилцаа тогтооход тус болох үүрэгтэй. Нийгмийн ажилтан нь мөн нийгэмшүүлэх циркийн сургагч багштай зохицон, уялдаатай хослож ажиллах ёстой.

Нийгмийн ажилтны үүргүүдийн нэг бол нийгэмшүүлэх циркийн улирлын тоглолтыг бэлтгэл ажлыг хангах юм. Өөрөөр хэлбэл, шинэ элсэлт авах, тохиромжтой байр талбай хайх, сургалт бэлтгэлийн төлөвлөгөө гаргах зэрэг орно. Түүнчлэн, бэлтгэл сургалтын явцад оролцогчидтой итгэлцлийн харилцаа тогтоох, нийгэмшүүлэх циркийн үр нөлөөг бий болгох зайлшгүй нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй. Сургалтын агуулга, хурд нь оролцогчдын чадавхи, хэрэгцээнд тохирсон мөн эдгээр тодорхой элементүүд нь тухайн хамт олны онцлогт нийцсэн байх явдлыг нийгмийн ажилтан нь хангах үүрэгтэй. Эцэст нь, тухайн ажилтан бэлтгэл сургалтын дүрмийг хүн бүр ойлгож, хүндэтгэж байх явдлыг хангах хэрэгтэй. Сүүлчийн хүчин зүйл нь итгэлцлийн харилцааг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй бөгөөд энэ нь бие биеэ хүндэтгэсэн, шудрага, аюулгүй байдал тогтооно.

Нийгэмшүүлэх циркийн сургалтын хэрэгсэл

Сургалтын үйл ажиллагааг дэмжих үүднээс, *Нарны Цирк* дасгалжуулагч, нийгмийн ажилтнууд болон сургагч багш нарыг зохих сургалтын материалаар хангахыг зорьсон юм. Одоогоор боловсрол сургалтын гурван материал бэлэн болоод байна. Үүнд: *Нийгмийн ажилтанд зориулсан гарын авлага*, *Циркийн урлагт суралцах үндсэн техник*, болон *Нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагчид зориулсан гарын авлага*.

Нийгмийн ажилтанд зориулсан гарын авлага: Энэхүү материал нь нийгэмшүүлэх циркийн хандлагын дүгнэлт мөн практик зааварчилгаа болох бөгөөд нийгмийн ажилтнуудад хөндлөнгөөс оролцох арга барилын үндсэн удирдах зарчмыг зааж, нийгэмшүүлэх циркийн бэлтгэл сургалтыг зохион байгуулах, төлөвлөх, үнэлэхэд дэмжлэг болох юм.

Циркийн урлагт суралцах үндсэн техник: Энэхүү материал нь техникийн гарын авлага болон боловсрол сургалтын хэрэгсэл аль аль нь бөгөөд үүнд циркийн урлагийн үндсэн 17 сургалтаас гарах 177 техникийн элементийг тусгасан байгаа. Дүрс бичлэг дагалдсан энэхүү бүтээл нь аюулгүй орчинд дэвшилтэт болон мэргэшсэн зааварчилгааг хүргэх боломжийг бүрдүүлсэн нарийн мэргэшлийн туршлага, техникийн агуулга тусгаж өгсөн.

Нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагчийн гарын авлага: Дасгалжуулагчдад зориулсан энэхүү 14 модуль бүхий материал нь нийгэмшүүлэх циркийн сургагч багш нар болон нийгмийн ажилтнуудад зориулсан үндсэн сургалтын салшгүй хэсгүүдийг оруулж өгсөн. Модуль тус бүрт зорилго, гол санаа, нийгэмшүүлэх циркийн дадлагажигч нарын сэтгэгдэл, тодорхойлолт зэргийг тусгасан байгаа.



Нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагчийн гарын авлага дараах модулаас бүрдэнэ: нийгэмшүүлэх цирк, сургагч багш болон нийгмийн ажилтны үүрэг, эрсдэлд буй залуус, ёс зүй, аюулгүй байдал, бүтээлч байдал, харилцаа холбоо, багийн ажил, боловсролын хандлага, бэлтгэл сургалтын төлөвлөлт, хослон заах болон багийн менежмент, түншлэл, зөрчлийн менежмент, соёл хоорондын харилцаа.

Нийгэмшүүлэх циркийн сургагч багш

Циркийн жүжигчний гол үүрэг нь нийгэмшүүлэх циркийн бэлтгэл сургалтын оролцогчдод циркийн янз бүрийн хичээлийг заах явдал юм. Сургагч багш нар нь өөрсдийн хамтран ажиллах тухайн хамт олон, оролцогчид болон орон нутгийн байгууллагуудын тодорхой шаардлагад зохицохын тулд өөрсдийн боловсрол сургалтын хандлагыг зохицуулах хэрэгтэй. Энэ утгаар, сургагч багш нар нь нийгэмшүүлэх циркийн нийгмийн ажилтантай нэгдмэл, уялдаатай хослон ажиллах үүрэгтэй. Сургагч багшийн гол үүрэг бол циркийн арга техникийг заах, бэлтгэл сургалтыг зохион байгуулах, төлөвлөх, туслан дэмжих, хөгжүүлэх, мөн нийгмийн ажилтан болон орон нутгийн түнштэй хамтран төслийг удирдан зохицуулах үүрэгтэй. Түүнээс гадна, өөрсдийн гаргаж буй үйлдэл дэх нийгмийн нөлөөнд мэдрэмжтэй байхын хажуугаар түнш байгууллагуудтай сайн харилцаа тогтоох, сургалтын оролцогчдын талаарх хамт олны гишүүдийн хандлагыг өөрчлөх үүднээс тухайн хамт олонтой хамтран ажиллах, үе үе хөндлөнгөөс оролцох үүрэгтэй. Сургагч багш бол жинхэнэ жүжигчин хүн бөгөөд эрсдэлд буй хэн нэгэнд туслах зорилгоор өөрийн авьяас билгийг ашиглахыг сонгосон нэгэн.

Нийгэмшүүлэх циркийн тоглолтын улирал

Нийгэмшүүлэх циркийн багц сургалтанд 20 орчим оролцогчидтой баг хамрагддаг. Тоглолт гол төлөв нийтийн үзүүлбэр тоглолтоор дуусдаг. Улирлын тоглолт ерөнхийдөө хоёроос арван сар хүртэл үргэлжлэх бөгөөд энэ нь хичээлийн жилийн хуанлиг дагах хандлагатай байдаг. Бэлтгэл сургалтыг багийн оролцоо болон байгаа нөөц бололцоог харгалзан төлөвлөдөг. Улирлын тоглолтын зорилго бол оролцогчдыг өөрийгөө хүндлэх, бусдад итгэх итгэлийг нь нэмэгдүүлэх, өөрсдийнх нь бүтээлч байдал, нөөц бололцоог нь нээхэд туслах замаар хувийн болон нийгмийн хөгжилд хүрэхэд нь туслах явдал юм. Нийтийн үзүүлбэр тоглолтын дараа, оролцогчид сүүлчийн удаа багийн уулзалт хийж, ирээдүй болон жинхэнэ бодит байдал дээр улирлын тоглолтын явцад сурсан зүйлээ хэрхэн нэвтрүүлэхийг ярилцана. Жишээ нь, циркийн сургамжийг яаж амьдралын сургамж болгох тухай.

Нийгэмшүүлэх циркийн дасгалжуулагч

Циркийн сургагч багш болон нийгмийн ажилтнуудад нийгэмшүүлэх циркийн үндэс ба дэвшилтэд ойлголтыг мэргэжлийн хүн заана. Дасгалжуулагч нар нь гол төлөв нийгэмшүүлэх циркийн талаар арвин дадлага туршлагатай циркийн жүжигчид буюу нийгмийн ажилтнууд байдаг. Тэдгээр нь улирлын бэлтгэл сургалтыг өөр циркийн мэргэжилтэн аль эсвэл нийгмийн хөндлөгөөс оролцогч мэргэжилтэнтэй хамтран хослон удирдах үүрэгтэй. Хамтдаа тэд нэмэлт арга замаар хэрхэн ажиллаж болохыг илүү тодорхой харуулж чадна. Дасгалжуулагч нар өөрсдийн заах арга барилыг сургалтын баг болон тэдний хамт олны соёл, нийгмийн бодит байдалд илүү зохицуулахыг хичээдэг бөгөөд сургагч багш нар болон нийгмийн ажилтнуудыг нийгэмшүүлэх циркийн хандлагын талаар зөв ойлголтыг хөгжүүлж, эргэцүүлэн бодоход нь үйл ажиллагаа болон тухайн цаг мөчийг ашиглаж тусладаг. Энэхүү хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн цагаас хойш, тус сургалтанд дэлхийн 25 гаруй орноос 2000 орчим нийгэмшүүлэх циркийн сургагч багш болон нийгмийн ажилтан хамрагдсан байна. Чухамдаа уг хөтөлбөр нь Дэлхийн Циркийн түншүүд зэрэг 100 гаруй өөр өөр байгууллагад нөлөөлсөн ажээ.

Нийгэмшүүлэх циркийн сургалт

2000 онд “Нарны Цирк” нь нийгэмшүүлэх циркийн сургагч багш болон нийгмийн ажилтнуудын боловсролын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор сургалтын хөтөлбөр боловсруулан гаргасан билээ. Орон нутгийн байгууллагуудтай түншийн холбоотой эхэлсэн энэхүү нийгэмшүүлэх циркийн сургалт нь хувийн болоод мэргэжлийн ёс зүйг өндөр түвшинд хөгжүүлэх, оролцогчдын боловсролын оролцооны шинэ хандлагын ерөнхий зарчмыг нэвтрүүлэх, заасан хичээл болон хамт олны бодит амьдралын хооронд гүүрэн холбоос тогтоох, циркийн урлагийг хувь хүнийг хөгжүүлэх өвөрмөц хэрэгсэл болгон ашиглахыг зорьсон юм. Нийгэмшүүлэх



циркийн улирлын сургалтыг гол төлөв хоёр дасгалжуулагч явуулдаг (нэг циркийн дасгалжуулагч, нэг нийгмийн ажилтан) бөгөөд сургалтанд 20-25 нийгэмшүүлэх циркийн сургагч багш болон нийгмийн ажилтнууд хамрагддаг. Сургалт долоо хоног орчим үргэлжлэх ба дараах тусгай сэдвийн хүрээнд янз бүрийн үйл ажиллагаа явуулдаг: хослон заах багийн гүйцэтгэх үүрэг, эрсдэлд буй залуучуудтай ажиллах, ёс зүй, аюулгүй байдал, бүтээлч байдал, харилцаа холбоо, багаар ажиллах, боловсролын хандлага, бэлтгэл сургалтын төлөвлөгөө, түншүүдтэй хамтран ажиллах, зөрчлийн менежмент, болон соёл хоорондын харилцаа зэрэг орно. Сургалтаар мөн циркийн урлаг болон багийн тоглоомыг хэрхэн заах талаар тусгайлан цаг гаргаж заах болно.

Нийгэмшүүлэх циркийн бэлтгэл сургалт

Долоо хоногт нэг буюу хоёр удаа, нийгэмшүүлэх циркийн бэлтгэл сургалт дунджаар гурав орчим цаг үргэлжилдэг. Дээрх сургалтанд 20 буюу түүнээс дээш оролцогчидтой байх ба гол төлөв нэг нийгэмшүүлэх циркийн сургагч багш, нэг нийгмийн ажилтнаас бүрдсэн хослон заах баг сургалтыг явуулдаг. Сургалтаар оролцогчдод янз бүрийн циркийн арга техник (жонглёр, акробат, модон хөл дээр явах, ганц дугуйн дээр явах, транплин зэрэг)-ийг танилцуулдаг бөгөөд мөн театрын болон алиалагчийн дүрийг ч танилцуулдаг. Оролцогчид янз бүрийн сэдвээр санал бодлоо хуваалцаж мөн өөрийгөө илэрхийлэх явдалд суралцахын тулд сургалтын эхэн ба төгсгөлд харилцан ярианд оролцдог.

Хослон заах

Нийгэмшүүлэх циркийн хүрээнд, нийгэмшүүлэх циркийн сургагч багш болон нийгмийн ажилтан нь хамт баг болж, нэгдмэл, зохицол нийцэлтэй ажиллахыг хослон заах гэж хэлнэ.



НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРКИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

СУРГАЛТЫН ҮНДСЭН ЗОРИЛТ: Жишээ нь: Нэгдмэл баг бүрдүүлэх – Оролцогчид болон олон нийтийн хоорондын харилцааг сайжруулах – Охид хөвгүүд хоорондын харилцааг сайжруулах. – Оролцогчдын өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх – Оролцогчдод өөрийн биенийг хянаж сурах явдлыг дэмжих. – ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх тал дээр мэдлэг ойлголтыг нь нэмэгдүүлэх – Оролцогчдын хар тамхи, согтууруулах ундааны хэрэглээг багасгах тал дээр туслах.

7 хоног	АРГА ТЕХНИКИЙН ЗОРИЛГО НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРКИЙН ХИЧЭЭЛ	НИЙГМИЙН ЗОРИЛГО АМЬДРАЛЫН ХИЧЭЭЛ
1	<p>БЛОК 1- ЦИРКИЙН АРГА ТЕХНИКИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА</p> <p>4 долоо хоног</p> <p><i>Циркийн арга техник нь баг бүрдүүлэх зорилготой хамааралтай учир танилцуулах</i></p> <ul style="list-style-type: none"> • Оролцогчдын бие бялдрын чадварыг үнэлэх. • Сорих үйлдлийг аажмаар ашиглах, биед хүрэхэд мэдрэмжтэй байх. 	<p>БЛОК 1 - БАГ БҮРДҮҮЛЭХ</p> <p>4 долоо хоног</p> <ul style="list-style-type: none"> • Оролцогчдыг угтан авч, хоёр талын дэмжлэг ба шинэ харилцааг хөхиулэн дэмжих. • Багийн бүрэлдэхүүн болон тэдний хэрэгцээг үнэлэх. (манлайлагч, загвар үзүүлэгчдийн харилцаа гэх мэт) • Мөрдөх ёс журмыг бий болгох.
2		
3		
4		
5	<p>БЛОК 2 – ЧАДВАР ШААРДСАН ТЕХНИКТ СУРАЛЦАХ</p> <p>6 долоо хоног</p> <p><i>Оролцогчдод циркийн арга техникийн дохио командыг зааж, багийн хамтын ажиллагааг дэмжих</i></p> <p>Бүх арга техникийг нарийн сурга.</p> <ul style="list-style-type: none"> • Илүү итгэлцэл шаардсан арга техникийг эрчимжүүл (пирамид байгуулах, гар гар дээрээ зогсох зэрэг) • Бүтээлч дасгал, тайзны урлагыг онцло. 	<p>БЛОК 2 – БАГИЙН НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ТОГТООХ</p> <p>6 долоо хоног</p> <p><i>Багийн хамтарсан ажиллагааг дэмжих, дасгалыг үргэлжлүүлэх.</i></p> <ul style="list-style-type: none"> • Албан болон албан ёсны бус цугларалтыг дэмжих. • Хувийн болон нийгмийн өсөлтийг дэмжих дасгалыг онцлох (өөртөө итгэлцэл бий болгох зэрэг) • Оролцогчдын дунд ая тухтай байдал тогтооход туслах. • Сургалт болон нийгмийн дэмжлэг авах тал дээр багийн нөөц бололцоог ашиглах.
6		
7		
8		
9		
10		
11	<p>БЛОК 3 – ЦИРКИЙН НЭГ ТЕХНИК ДЭЭР ТӨВЛӨРӨХ</p> <p>3 долоо хоног</p> <ul style="list-style-type: none"> • Үзүүлбэрийн тоог гаргах. • Үзүүлбэрүүдийг ар араас нь давтах 	<p>БЛОК 3 – БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРЧИМЖҮҮЛЭХ</p> <p>3 долоо хоног</p> <ul style="list-style-type: none"> • Багийн төсөлд хувь нэмэр оруулах ур чадварын хөгжлийг дэмжих: тоглолтонд зориулж шийдвэр гаргах болон стрессын менежментийг нэвтрүүлэх
12		
13		
14	<p>БЛОК 4 – СҮҮЛЧИЙН БЭЛТГЭЛ БОЛОН ТОГЛОЛТ</p> <p>BLOCK 4 – FINAL RUN-THROUGH AND PERFORMANCE</p>	
15	<p>БЛОК 5 – СУРСАН ЗҮЙЛДЭЭ ДҮГНЭЛТ ХИЙХ</p> <p>1 бэлтгэл сургалт</p> <ul style="list-style-type: none"> • Тоглолтыг дүгнэх (дүрс бичлэг үзэх зэрэг). • Сурсан арга техникийг үнэлэх. 	<p>БЛОК 5 – БАГИЙН ТУРШЛАГЫГ ДҮГНЭХ</p> <p>1 бэлтгэл сургалт</p> <ul style="list-style-type: none"> • Баг болон хувь хүмүүсийн хөгжил дэвшлийг дүгнэх. • Дараагийн хөтөлбөрт зориулж мэдээлэл солилцож, аль эсвэл бусад нөөц бололцооны талаар дурдах.



НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРКИЙН ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ХИЧЭЭЛИЙН ЕРӨНХИЙ ЗОРИЛГО:

7хоног	АРГА ТЕХНИКИЙН ЗОРИЛГО НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРКИЙН ХИЧЭЭЛ	НИЙГМИЙН ЗОРИЛГО АМЬДРАЛЫН ХИЧЭЭЛ
1		
2		
3		
4		
5		
6		
7		
8		
9		
10		
11		
12		
13		
14		
15		



НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРКИЙН СУРГАЛТЫГ ТӨЛӨВЛӨХ

Бэлтгэл сургалт: #2	Хугацаа: 3 цаг	Оролцоо: 7 охин 14 хөвгүүн
Сургагч багш (нар): Мамаду, Женевьев	Нийгмийн ажилтан(нар): Алис	Бусад: Ү/т

СУРГАЛТЫН ЕРӨНХИЙ ЗОРИЛГО:

Оролцогчдын талаар олон нийтийн ойлголт болон олон нийтийн талаарх оролцогчдын ойлголтыг өөрчлөх

ЦИРКИЙН СУРГАЛТЫН ЗОРИЛГО ЦИРКИЙН ХИЧЭЭЛ	НИЙГМИЙН СУРГАЛТЫН ЗОРИЛГО АМЬДРАЛЫН ХИЧЭЭЛ
<ul style="list-style-type: none"> Бие халаалт хийж занших. Зарим циркийн үзүүлбэрүүдийг судлах: пирамид босгох, гар холбоос, жонглёр 	<ul style="list-style-type: none"> Холбоо тогтоож, шинэ харилцааг дэмжих (багийн болон итгэлцэл бий болгох үзүүлбэр) Багийг сэдэлжүүлж, хөгжилтэй байж, амжилтыг дэмжих

ХУВААРЬ

Ойролцоогоор үргэлжлэх хугацаа	Үйл ажиллагаанууд (мэндчил-гээ, завсарлага, дүгнэлт/хаалт зэрэг бүх үйл ажиллагааны жагсаалт)	(Үйл ажиллагааны чиглүүлэгч) (нэр)	Үйл ажиллагаанд шаардлагатай зүйлс (материал, аюулгүй байдал, бие халаалт, баг бүрдүүлэх, сэдвийн ярилцлага гэх мэт)	Гүйцэтгэл	
				Тийм	Үгүй
10 мин.	Оролцогчдыг угтаж авах	Бүгд	Эхлэхэд сэтгэл санааны хувьд бэлэн байх	X	
5 мин.	Бэлтгэл сургалтыг тайлбарлах	Алис		X	
15 мин.	Үзүүлбэрийн нэр: Өндөрт харайх (магтаж нэрээр нь дуудах)	Мамаду	Шохой	X	
15 мин.	Үзүүлбэр: Гурвалсан өргөлт	Женевьев	3 бөмбөг, 3 баг	X	
15 мин.	Бие халаалт	Мамаду, Женевьев	Гимнастикийн гудас	X	
20 мин.	Багийг зоригжуулах: Олсон дор!	Алис	3 баг, гимнастикийн гудас, олс	X	
10 мин.	Завсарлага	Бүгд	Ундаа, зууш, оролцогчдод туслах, албан бус яриа өрнүүлэх	X	
45 мин.	2 хувилбарт ажил: Жонглёр ба гар холбоос	Мамаду (жонглёр) Женевьев (гар холбоос)	2 баг, бөмбөг, гудас Мамаду= цаг + баг солигдох дарааллыг хариуцна.	X	
25 мин.	Пирамид босгох	Женевьев	Гудас, дэвтэр, пирамид зурах		X
5 мин.	Тоног төхөөрөмж хураах	Бүгд		X	
10 мин.	Дүгнэлт: Микрофон-той ярилцлага (микрофоны оронд жонглёрын мод ашиглах)	Алис	1 жонглёрын мод	X	
5 мин.	Хаалт: Дээсэн тойрог	Мамаду	1 бат бөх олс, үзүүрийг нь чанга холбосон		X

ДАРААГИЙН ШАТ

ЕРӨНХИЙ ТАЙЛБАР:

(Багийн барилдлага, тулгарсан сорилтууд, нийгмийн хөндлөгийн оролцоо, шийдэх өөрчлөлтүүд зэрэг)

- Сайн баг бүрдсэн ба итгэлцэл бий болсон. Жижгэвтэр баг бүрдүүлэх үед найз нөхөд, хамтрагчдыг тусгаарлах.
- Зарим тохиолдолд, гар холбоосын дасгал бага зэргийн таагүй байдал, ичиж зовох байдал үүсгэдэг. Илүү таатай арга хай.
- Дараагийн бэлтгэл сургуулалтын үед, пирамид босгоход илүү цаг гаргах.
- Зарим оролцогчид бусдын талаар таагүй тайлбар тавих үед нэг их оролцохгүй байх.
- Завсарлаганы үеэр орхиж явсан Валентиног шалгах.
- Жонатан, Ребекка нар баг дотор бүрэг ичимхий байна.

ДАРААГИЙН СУРГАЛТЫН ЗОРИЛГО:

- Жонглёр болон гар холбоосыг үргэлжлүүлэх. Пирамид болон “рола бола”-г танилцуулах.
- Оролцогчид хоорондын харилцааг үргэлжлүүлэн дэмжих. Жонатан, Ребекка хоёрыг багт оруулахад тодорхой хүчин чармайлт гаргах.

НИЙГЭМШҮҮЛЭХ ЦИРКИЙН СУРГАЛТЫГ ТӨЛӨВЛӨХ

Бэлтгэл сургалт:	Хугацаа:	Оролцоо/Ирц:
Сургагч багш (нар):	Нийгмийн ажилтан(нар):	Бусад:

СУРГАЛТЫН ЕРӨНХИЙ ЗОРИЛГО:

СУРГАЛТЫН АРГА ТЕХНИКИЙН ЗОРИЛГО
ЦИРКИЙН ХИЧЭЭЛ

НИЙГМИЙН ЗОРИЛГО
АМЬДРАЛЫН ХИЧЭЭЛ

ХУВААРЬ

Ойролцоогоор үргэлжлэх хугацаа	Үйл ажиллагаанууд (мэндчилгээ, завсарлага, дүгнэлт/хаалт зэрэг бүх үйл ажиллагааны жагсаалт гаргах)	(Үйл ажиллагааны чиглүүлэгч) (нэр)	Үйл ажиллагаанд шаардлагатай зүйлс (материал, аюулгүй байдал, бие халаалт, баг бүрдүүлэх, сэдвийн ярилцлага гэх мэт)	Гүйцэтгэл	
				ТИЙМ	ҮГҮЙ

ДҮГНЭЛТ

ЕРӨНХИЙ ТАЙЛБАРУУД:

ДАРААГИЙН СУРГАЛТЫН ЗОРИЛГО:





ҮЙЛ АЖИЛЛАГАА

СЭДЭВ

ДЭС ДАРААЛАЛ

СЭТГЭГДЭЛ





ҮЙЛ АЖИЛЛАГАА

СЭДЭВ

ДЭС ДАРААЛАЛ

СЭТГЭГДЭЛ





ҮЙЛ АЖИЛЛАГАА

СЭДЭВ

1. ТУРШЛАГА

Ямар нэгэн зүйл болж байна!



4. НЭВТРҮҮЛЭХ

*Миний дадалтай ямар
холбоотой вэ?*

2. АЖИГЛАЛТ

*Юу болсон
бэ?*



3. НЭГТГЭЛ

Яагаад ийм үр дүнд хүрсэн бэ?





ҮЙЛ АЖИЛЛАГАА

СЭДЭВ

1. ТУРШЛАГА

Ямар нэгэн зүйл болж байна!



4. НЭВТРҮҮЛЭХ

*Миний дадалтай ямар
холбоотой вэ?*

2. АЖИГЛАЛТ

*Юу болсон
бэ?*



3. НЭГТГЭЛ

Яагаад ийм үр дүнд хүрсэн бэ?



САНАЛ БОЛГОСОН ҮЗҮҮЛБЭР/ТОГЛООМ

ҮЗҮҮЛБЭРИЙН НЭР:

ҮЗҮҮЛБЭРИЙН ХУГАЦАА:

ОРОЛЦОГЧДЫН ТОО:

ГОЛ ЗОРИЛГО:

(Жишээ нь: бие халаалт, багаар ажиллах, хөдөлгөөний эвсэл, төвлөлөрөлт, эрч хүч өгөгч, нээлт, хаалт зэрэг)

МАТЕРИАЛ:

ДЭС ДАРААЛАЛ:

ТАЙЛБАР БОЛОН ИЖИЛ ТӨСТЭЙ ҮЗҮҮЛБЭРҮҮД (БУСАД ХУВИЛБАРУУД):

ҮЗҮҮЛБЭР САНАЛ БОЛГОСОН ОРОЛЦОГЧИЙН НЭР:



САНАЛ БОЛГОСОН ҮЗҮҮЛБЭР/ТОГЛООМ

ҮЗҮҮЛБЭРИЙН НЭР:

ҮЗҮҮЛБЭРИЙН ХУГАЦАА:

ОРОЛЦОГЧДЫН ТОО:

ГОЛ ЗОРИЛГО:

(Жишээ нь: бие халаалт, багаар ажиллах, хөдөлгөөний эвсэл, төвлөлөрөлт, эрч хүч өгөгч, нээлт, хаалт зэрэг)

МАТЕРИАЛ:

ДЭС ДАРААЛАЛ:

ТАЙЛБАР БОЛОН ИЖИЛ ТӨСТЭЙ ҮЗҮҮЛБЭРҮҮД (БУСАД ХУВИЛБАРУУД):

ҮЗҮҮЛБЭР САНАЛ БОЛГОСОН ОРОЛЦОГЧИЙН НЭР:



